



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/02

Онги

Мөсний баяр-2024 арга хэмжээг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-Овоо сумын иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, өвлийн спортыг дэмжих зорилгоор “Мөсний баяр-2024” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Мөсний баяр-2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээний хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. “Мөсний баяр-2024” арга хэмжээний ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг төрийн байгууллагууд, аж ахуй нэгж, иргэд олон нийтэд уриалсугай.


4. “Мөсний баяр-2024” арга хэмжээний хөтөлбөр тэмцээний удирдамжийг боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга, арга хэмжээг зохион байгуулахад хамтарч ажиллахыг Мааньт багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

Сайхан-Овоо сумын Засаг даргын  
2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 4/07  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




**“МӨСНИЙ БАЯР-2024” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: Мааньт багийн Засаг дарга  
Гишүүд:  
Засаг даргын тамгын газрын дарга  
Санхүүгийн албаны дарга  
Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
Ерөнхий боловсролын сургуулийн захирал  
Цэцэрлэгийн эрхлэгч  
Эрүүл мэндийн төвийн дарга  
Соёлын төвийн эрхлэгч  
Онги багийн засаг дарга  
Найз багийн засаг дарга  
Төгрөг багийн засаг дарга  
Хэсгийн төлөөлөгч



Сайхан-Овоо сумын Засаг даргын  
2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/07  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



### “МӨСНИЙ БАЯР-2024” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хугацаа: 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Байршил: Хадан хошуу

10:00-10:20 Тэмцээний оролцогчдын бүртгэл

10:20-10:40 Нээлтийн арга хэмжээ /Мэндчилгээ Соёлын төв/

10:40-11:40 Тэшүүрийн тэмцээн /насанд хүрэгчид/

11:40-13:00 Тэшүүрийн тэмцээн /хүүхэд /

13:00-14:00 Хээрийн шилдэг цай шалгаруулах

14:00-15:00 Мөсөн дээрх сумо бөхийн тэмцээн

14:00-15:00 Мөсөн шагай тэмцээн

15:00-16:00 Мөсөн дээрх буухиа тэмцээн

16:00-17:00 Мөсөн дээрх олс таталтын тэмцээн

17:00 Тэмцээн уралдааны шагнал гардуулах ёслол

18:00 Мөсний баярын хаалтын үйл ажиллагаа /Шоу цэнгүүн Соёлын төвд/

